


Хэл ярианы хөгжил-I

(Тэгш хамруулах боловсрол)

Бие даах ажлын дэвтэр
(I-V анги)



< Ярих, сонсох >

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Зургийг ажиглаад, юуны зураг болохыг нэрлэцгээе. Байгалийн дуу авиаг дуурайн дуугараарай.



.....)

2 Хөдөлгөөнөөр үзүүлээрэй. Үзүүлснээ тэмдэглээрэй

- Бороо орох чимээг тогшилтоор хийж үзүүлнэ үү. (.....)
- Шируун бороо орж байгааг тогшилтоор хийж үзүүлээрэй. (.....)
- Тэнгэр дуугарах чимээг алга ташилтаар хийж үзүүлцгээе. (.....)

3 Амьтдыг нэрлээд, дуурайн дуугарцгаая (энэ тохиолдолд аудио бичлэг, CD, DVD ашиглаж болно).



.....)


4 Юу дуугарсан бэ? тааж тоглоцгооё. Харьцуулаарай. (биетээр болон аудио бичлэгээр сонсгох)

Харьцуулах зүйлс	Ялгаатай тал
 ба	
 ба	
 ба	

Дууссан: он сар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:





< Ярих, сонсох >

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1

Ямар хөгжим бэ? нэрлээрэй. Бөмбөрийг 3, 5, 7 удаа цохиж үзүүлээрэй.



2

Ямар дууны ая вэ? сонсоод таацгаая. Хамтдаа дуулцгаая. /Сонсох аяыг бэлтгэсэн байна/

- Төрийн дуулал
- Бөмбөг
- Тоглоом
- Тавтай сайхан нойрсоорой

1. Монгол Улсын Төрийн дуулал

Дархан манай хувьсгалт улс
 Даяар Монголын ариун голомт
 Дайсны хөлд хэзээ ч орохгүй
 Дандаа энхжин үүрд мөнхөжнө



Хамаг дэлхийн шударга улстай
 Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж
 Хатан зориг, бүхий л чадлаараа
 Хайртай Монгол орноо мандуулья

2. Бөмбөг

Бөмбөг бөмбөг хөөрхөн дөө
 Бөмбөгөөр тоглох гоёхон доо
 Хөөрхөн алаг бөмбөгөөр
 Харилцан тоглоё хоёулаа



3. Тоглоом

Тогоруу янзын хүүхэлдэй
 Тоодог бяцхан ангаахай
 Ойн хүрэн баавгай
 Олон янзын шувуунууд
 Дэлдэн чихтэй туулай
 Дээгүүр явдаг онгоц
 Доогуур явдаг машин
 Дээшээ хөөрдөг бөмбөг
 Хүүхэлдэй сайхан амраарай




Дууссан: он сар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:



< Ярих, сонсох >

Сурагчийн нэр:



Эхэлсэн: он сар өдөр.....цаг

1 Дууг сонсоод, хөдөлгөөн хийж үзүүлнэ үү. /Болжмор/

- Хөгжмийг сонсоод, дагаад аялаарай.
- Хөгжмийн аянд тохируулан бүжиглэцгээе.
- Энэ дуунд ямар шувууны тухай гарч байна, чи энэ шувууг мэдэх үү?
- Дууны нэрийг хэлээрэй.

Болжмор

Жижигхэн болжмор жив жив жив
Жиргэж нисээд дэв дэв дэв
Амаа ангайгаад жив жив жив
Ангайн дэгдээд дэв дэв дэв
Тоглоё тоглоё жив жив жив



2 Багш, эцэг эх, асран хамгаалагчид дараах үгсийг дуудаж өгч, даалгаврыг хүүхдээр гүйцэтгүүлээрэй.

А, О, У авиа үгийн эхэнд сонсогдвол алгаа 2 удаа ташицгаая.
(уурга, аалз, одон, авдар, утас, оготно, угалз, ангаахай, оймс, унага)

А, О, У авиа үгийн дунд сонсогдвол гараа өргөнө үү.
(Осор, сав, хурга, шаазгай, хурал, онгоц, морин хуур, шавар, шагшуур, оосор)

А, О, У авиа үгийн адагт сонсогдвол ширээгээ тогшоорой.
(тагтаа, оноо, унаа, гарын хуруу, ачаа, Болдоо, сонсоно, далбаа, хороо, хяруу, Туяа, будаа)

Үгийн эхэнд Э, Ө, Ү, И авиа орсон үг тус бүр нэгийг хэлээрэй.
(эвэр, өвс, үнэг, индүү, ээрүүл, өвчүү, үлгэр, итгэл)

Үгийн дунд Э, Ө, Ү, И үсэг орсон үгний тохирох зургийг олцгооё.
(эмч, өндөг, үзүүр, ишиг, ээмэг, өндөр, үзэг, өлгүүр, хөшиг)

Үгийн адагт Э, Ө, Ү, И авиа сонсогдвол босож зогсоорой.
(эмээ, өвөө, хүзүү, миний, элээ, хөшөө, зүү, чиний, хэрээ, хөрөө, шүүр)


3 Зурагт юу дутуу дүрслэгдсэн байгааг олоод, нэрлэцгээе. “С”, “Ш” авиа тухайн үгэнд хаана сонсогдож байгааг ялган хэлцгээе.



Дууссан: он сар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:





1

“Хэн хамгийн олон үг хэлэх вэ? тоглоом тоглоцгооё.

Тоглоомын заавар:

Тоглохын өмнө эгшиг үсэг үгийн эхэн, дунд, адагт орсон зураг үзүүлж ярилцах, зургийг нэрлүүлж, идэвхтэй үгийн нөөцийг нэмэгдүүлнэ. Шоо орхиж тоглоно. 6 нүд буулгасан хүүхэд тоглоомыг эхлүүлнэ. Хэн олон зурагт карт нэрлэсэн нь хожно.

- 1 нүд буувал А үсэг үгийн эхэнд орсон үгтэй зурагт картыг үзүүлж нэрлэх
- 2 нүд буувал Ө үсэг үгийн эхэнд орсон үгтэй зурагт картыг үзүүлж нэрлэх
- 3 нүд буулгасан хүүхэд Ү үсгээр эхэлсэн үгтэй зурагт картыг үзүүлж нэрлэх
- 4 нүд буулгасан хүүхэд И үсгээр эхэлсэн үгтэй зурагт картыг үзүүлж нэрлэх
- 5 нүд буулгасан хүүхэд О үсгээр эхэлсэн үгтэй зурагт картыг үзүүлж нэрлэх
- 6 нүд буулгасан буулгасан хүүхэд дурын зурагт картыг үзүүлж нэрлэнэ.

2

Зургийг ажиглаад, юу юу байгааг нэрлэнэ үү.




- Үгийн эхэнд ямар авиа сонсогдож байна?
- Сонссон авиагаа хэлээрэй.
- Өөрийн сонголтоор зурагнаас сонгож зурна уу.

.....

3

Дараах зургуудыг нэрлээд, Ш, С, Ц авиа сонсогдож байгаа үгийг олж нэрлээрэй.

Өөрийн сонголтоор зургийг зурцгаая.




4

Зургаас С авиа орсон зургийг олж, өгүүлээр зохионо уу.



.....
.....





1 Шүлгийг сонсож, цээжлээрэй.



Хэрэм

Соотойсон чихтэй
Сормойсон нүдтэй
Сагсайсан сүүлтэй
Сааралхан хэрэм
Самар цөмөхдөө
Сармагчин шиг
Дархинаас дүүлэхдээ
Далавчтай юм шиг

2 Оньсого таацгаая. Утгыг ярилцана уу.

Үр нь хар
Үндэс нь цагаан
Гээг нь ногоон
Гэдэс нь цүдгэр

Тэр юу вэ?

(.....)



3 Зургийг ажиглаад, юу юу дүрслэгдсэн байгааг хэлээрэй. Үгийн эхэнд сонсогдож байгаа авиаг зөв дуудаж хэвшээрэй.



.амар




.рслан



.ус





1

Дараах өгүүлбэрт С, Ш авиа сонсогдож байгаа үгсийг олж, доогуур нь зурж тэмдэглэнэ үү.

Түүвэр өгүүлбэр


Шөнө тэнгэрт сар гарав. Эгч шар будгаар шал будав. Энэ шал шар өнгөтэй.

Би шөнө сар харав. Эгч шалаа угаав. Дүү сар зурав.

Энэ зурагт шалыг шараар, сарыг цагаанаар зурсан байна. Эмээ саранд сүү өргөв.

2

Үгсийг уншаад утгыг тайлбарлацгаая. Авиаг буруу дуудах эсвэл соливол үгийн утга өөрчлөгдөж байна уу?

сав – шав савар – шавар сал – шал		хасаа – хашаа хус – хуш хайс – хайш
---	--	---

- Үгийн утга өөрчлөгдөхгүй.
- Үгийн утга өөрчлөгдөнө.

3


Цэгийн оронд С, Ш үсгийн аль тохирохыг нөхөж бичнэ үү.


Зуслан

Манайх ойн захад байрлах зу . ланд гарлаа. Ойд ху . , нар . , ху . зэрэг олон төрлийн мод ургадаг. Зус . анд ол . н найз- ай бол . он.

4

“Зусланд” сэдэвт зураг зурцгаая.





1 Үг бүтээж, харьцуулан уншъя. Үгсийн утгыг тайлбарлан ярина уу.

са → наа
→ раа
→ нал

ша → л
→ р
→ в

2 Зургийн нэрийг бичихдээ С-Ш үсгийг зөв сонгоорой. Өгүүлбэр зохионо уу.



.....
.....
.....

3 С үсгийг Ш үсгээр сольж үг бүтээгээд, үгийн утгыг тайлбарлацгаая.

хас-хаш

хас-тоог хас

хаш – хаш чулуу

сар-

цаас-

тус-

савар-

4 Цэгийн оронд тохирох үсгийг нөхөж бичээд, түргэн хэлж сурцгаая.

(.)аврыг ху(.)аар хийнэ

(.)аврыг у(.)аар зуурна


5 Онъсогыг таагаад, утгыг ярилцаарай.

Тэнгэрээс утас уяатай
Утаснаас ухна дүүжлээстэй

Тэр юу вэ? Яагаад?
(а.....)

Уухай туухай баатар
Ууцан дундуураа тасархай баатар
Харваж оногдохгүй хар баатар
Хальтарч унахгүй хурдан баатар

Тэр юу вэ? Яагаад?
(ш.....)



1

“Хэн хамгийн зөв сонсох вэ?” тоглоом тоглоцгооё!

- “Ж”- авиа үгийн дунд сонсогдвол алгаа ташаарай.
- “З” авиа үгийн эхэнд сонсогдвол гараа өргөөрэй.

(сандал, цүнх, дүүжин, давс, чихэр, манжин, чинжүү, чихэр, хөгжим, цох, манжин, үзэг, шувуу, болжмор)

2


Цэгийн оронд Ж, З үсгийн аль тохирохыг нөхөөд, оньсогыг таагаарай.

Эрүүтэй бай.... өвчүүгүй

Сүүлтэй бай.... сүү...гүй

Тэр юу вэ? Яагаад?

(з.....)



3

Зургийг нэрлэн, ерөнхий нэр өгч, бичицгээе. Нэрэнд нь Ц, Чүсэг орсон ногооны ашиг шимийн тухай ярилцацгаая.

.....



.....

.....

.....

.....

.....


.....


4

Эхийг уншаад, ойлгосоноо зурцгаая.

Навч

Навч олон өнгөтэй байдаг. Намар болж, модны навчис шарлан уналаа. Манай ангийн хүүхдүүд модны унасан навчийг түүж хатаав. Хатаасан навчаар бид сонирхолтой наамал хийцгээв. Жамцын хийсэн “Намар” сэдэвтэй наамал гоё болжээ.





1 Хэн олон үг мэдэх вэ? Хүснэгтэд бичицгээе.

“Ц” үсэг орсон үг	“Ч” үсэг орсон үг
царцаа	чихэр

2 Дараах өгүүлбэрээс алдаатай бичсэн үгийг олж доогуур нь зураарай. Алдаатай үгийг зөв болгож, өгүүлбэрийг хуулж бичнэ үү.

Намар болж, манчин, байчай, сонгино, төмс хураан авав. Миний эгч ноосон цамч нэхэж өгөв. Би ууланд цоно явж байхыг харав.

.....
.....
.....

3 Түргэн хэллэгийг цээжлээд, хурдан, түгдрэлгүй хэлж сурцгаая.

Жалганд ургасан
Жалгын яргуйнаас
Жаран цоохор
Сэргэр, сэвсгэр сэрх
Сүргээрээ бүгдээрээ идээшилнэ.

4 Дараах үгсээр өгүүлбэр зохиож бичнэ үү.
(цамц, товч, навч, цана, чарга, чихэр, цонх)


.....
.....
.....

5 Зургийг ажиглаад, юу юу дүрслэгдсэн байгааг хэлээрэй. Үгийн эхэнд сонсогдож байгаа авиаг зөв дуудаж хэвшээрэй.







(.....)





1 Дараах үгийн утгыг ярилцаж, зургийг зурцгаая.




2 Хүснэгтийн мөр бүрээс хоёроос доошгүй үг оролцуулан өгүүлбэр зохиоцгооё.

Нэг	Цох	аргал	авчрав.
Би	хүн	сонин	түүв.
Ээж	байцай	шавар	дуртай.
Багш	савраар	идэх	зуурна.

3 Үгийн сүлжээ бөглөөрэй. Босоо нүдэнд ямар амьтны нэр байна вэ?

- Газар малтахад хэрэглэдэг багаж
- Өгүүлэх эрхтэний нэг
- Цай хийж уудаг зүйл
- Алтлаг шар өнгөтэй Амьтан бүхнийг гэрэлтүүлэгч Тэр юу вэ?
- Аль нь зөв бэ?




1. Цаан 2. Жаан 3. Чаан 4. Заан

4 Зөв бичигдсэн үгийг олцгооё. Зургийг ажиглаад, үлгэрийн үйл явдлын дагуу дугаарлаж, яриарай. Ямар нэртэй үлгэр бэ?

(манчин, манжин, манцин, мансин, маншин, манзин)





1 Асуултын дагуу өөрийгөө танилцуулаарай.

- Сайн байна уу?
- Чамайг хэн гэдэг вэ?
- Чи хэдэн настай вэ?
- Чи ямар сургуульд сурдаг вэ?
- Чи хэддүгээр ангид сурдаг вэ?

2 Зургийг ажиглан, нэр өгч, асуултын дагуу тайлбарлан ярина уу.



- Зурагт хэн, хэн байна вэ? Юу хийж байна вэ?
- Зурагт юу, юу байна вэ?

3 “Гэр бүл”, “Ажил мэргэжил” сэдвээр эх зохиож ярилцаарай.



- Эхний зураг дээр юу дүрслэгдсэн байна вэ?
- Дараагийн зураг дээр юу дүрслэгдсэн байна вэ?


.....

.....

.....

.....

.....



1 “Манай гэр бүл” сэдвээр ярилцацгаая.

Манай гэр бүл

- Танайх ам бүл хэдүүлээ, хэн, хэнтэйгээ амьдардаг вэ?
- Танай гэр хаана байдаг вэ?
- Сургууль, гэр хоёр нь хэр зайтай байдаг вэ?
- Гэр бүлийн гишүүд нь ямар ажил эрхэлдэг вэ?


2 “Манай анги” сэдвээр дараах асуултад хариулна уу.



- Чи хэддүгээр ангид сурдаг вэ?
- Танай анги хэдэн давхарт байрладаг вэ?
- Танай ангид юу, юу байдаг вэ?
- Танай ангийн багшийг хэн гэдэг вэ?
- Танай анги хэдэн хүүхэдтэй вэ?
- Танай анги хэдэн цонхтой вэ?
- Чи ангийн жижүүр хийдэг үү?
- Чиний хамгийн сайн найз хэн бэ?
- Чи ангийн найз нартаа юу гэж хэлэх вэ?

3 Зургийг ажиглаад, “Миний өдрийн дэглэм” сэдвээр харилцан ярилцъя.





1

“Миний хийх дуртай зүйл” сэдвээр бидэнд ярьж өгнө үү.

Тулгуур үгс: Зураг зурах, дуу дуулах, тоглох, хичээлдээ явах, ном унших, хуулан бичих, ярилцах, хүнд туслах, аяга, тавгаа угаах, гэрээ цэвэрлэх, кино үзэх, шатар, даам тоглох, зугаалах, биеийн тамирын дасгал хийх, хөдөө аялах, цахим тоглоом тоглох, мал маллах, уралдаан тэмцээнд оролцох, хүүхдийн нэвтрүүлэг үзэх гэх мэт

2

Гэрийн хаягаа мэдэцгээе. Гэрийн хаягаа бичиж, цээжлээрэй.

Миний оршин суугаа газар

Улс:
Аймаг, хот:
Сум, дүүрэг:
Баг, хороо:
Гудамж, байр
Тоот, хаалга

3

Зургийг ажиглаад, “Би сурагч” сэдвээр харилцан ярилцаарай.




- Сурагчийн гол хөдөлмөр юу вэ?

- Чи яагаад тэгж бодож байна вэ?

- Чи ямар хичээлд хамгийн сонирхолтой вэ? Яагаад?





1 Зургийг ажиглаад, Ц авиа үгийн хаана сонсогдож байгааг хэлнэ үү.



2 Эхийг уншаад, цайны тухай ярилцаарай.

Цай

Үндэстэн бүр өөрийн онцлогт тохирсон цай хэрэглэдэг. Монголчууд цайг эрхэмлэн дээдэлдэг. Цай хүний эрүүл мэндэд тустай. Манай ард түмэн сүүтэй цай их уудаг. Би борцтой, будаатай, хийцтэй цайнд дуртай.



3 Илүүц зургийг олж тэмдэглэнэ үү.




4 Салхины тухай эхийг уншаад ярилцана уу.

Манай сургууль

Манай сургууль хотын төвд байдаг. Сургуулийн анги танхим цэлгэр, саруулхан. Сургууль дээр олон дугуйлан хичээллэдэг. Сургуулийн биеийн тамирын заал том. Хүүхдүүд сагс, гар бөмбөг тоглодог. Багш нар мод тарив.




Four empty circles for rating




1 Цагаан толгойн дармал ба бичмэл үсгүүдээ ажиглацгаая. Бичмэл үсгүүдээ бичээрэй.

Цагаан толгой

Аа	Бб	Вв	Гг	Дд	Ее	Ёё
Жж	Зз	Ии	й	Кк	Лл	Мм
Нн	Оо	Өө	Пп	Рр	Сс	Тт
Уу	Үү	Фф	Хх	Цц	Чч	Шш
Щщ	ь	ы	ь	Ээ	Юю	Яя




2 Үндсэн эгшиг үсгийг гүйцээж бичээд, улаан өнгөөр будаарай.



3 Богино эгшиг үсгийг нөхөж бичиж, үг бүтээнэ үү.

с . м, м . с, н . м, с . х, х . р, с . л


4 Уншаад, богино эгшгийн доогуур зураарай.



5 Аль нь зөв бэ? тэмдэглээрэй.

- а. Эгшиг үсэг 7 байдаг.
- б. Эгшиг үсэг 13 байдаг.
- в. Эгшиг үсэг 6 байдаг.






1 Эгшиг нөхөж, шүлгийг гүйцээн бичнэ үү? Шүлгийг цээжлээрэй.

Асуулт

Хурга иш...г дуугарахад
 Майллаа гэс...н байтлаа
 Туг...л бяруу дуугарахад
 Мөөрлөө гэдэг нь х...чин юм
 Ун...га даага дуугарахад
 Унгалдлаа г...сэн атлаа
 Б...тго тором дуугарахад
 Буйллаа гэх нь с...нин юм
 Адилхан м...л мөртлөө
 Ижилхэн х...лээр ярьдаггүй юм уу



(3. Нямцэрэн)

- Ямар эгшиг нөхөж, үг бүтээсэн бэ?

- 1. Богино эгшиг
- 2. Урт эгшиг
- 3. Хос эгшиг

2 Урт эгшиг нөхөж бичээд, үг бүтээгээрэй.

.....в, л....., эм....., с....., өв.....
л, цаг.....н, ног.....н, бүр.....

3 Зүйр цэцэн үгийг уншаад, урт эгшгийн доогуур зураарай.

Эрдмийг хичээлээр сурдаг

Бороо дээлэн дээр ус

Эрлийг сургаар олдог

Дэлхий дээр тос

4 Онъсогыг таагаад, хуулан бичээрэй. Богино эгшгийн доогуур нэг, урт эгшгийн доогуур хоёр зурна уу.

Шингэн байтлаа ус биш

Өөхөн бөмбөөхий

Цагаан байтлаа цас биш

Араг сэгсээхий

Тэр юу вэ? Яагаад? (с . .)

Тэр юу вэ? Яагаад? (х . . .)

5 Богино эгшигтэй үг болгон бичээд, утгыг тайлбарлана уу.

уул- ул

хуур-.....

үүр-.....

хийл-.....

дээл-.....


цаас-.....

туул-.....

саам-.....

хоол-





1 Өгөгдсөн үгээр өгүүлбэр зохиогоод, урт эгшгийг улаан өнгөөр будаарай.

✓ Хүүхдүүд, амарчээ, сайхан

.....

✓ Арвин, ногоо, тариа, их, хураалаа)

.....

2 Илүүц үгийг олоорой.

- тэмээ, адуу, ямаа, үхэр, алим
- талх, сүү, хүүхэлдэй, тараг

3 Зургийг ажиглаад, нэрийг бичээрэй. Хос эгшгийн доогуур зурна уу.




4 Богино эгшиг орсон үгийг урт, хос эгшигтэй үг болгон хувиргаад, уншиж, бичнэ үү. Үгийн утга хэрхэн өөрчлөгдөж байгааг тайлбарлан яриарай. Жишээ нь:

- хул- хуул – хуйл
- ав –
- үр –
- хав –
- тор –

5 Давтаж уншаарай.

аз-аж, аз жаргал, аж амьдрал
 олз-олж, олз олох, олж харах
 угз- угж, угз татах, угж хийх





1 Хос эгшиг нөхөж бичээд, зүйр цэцэн үгийг цээжилнэ үү.

Хүн ахт.....

Эвт шаазг..... буга барина.

Дээл захт.....

2 Шүлгээс хос эгшиг орсон үгийг түүж бичээрэй.

Зэрлэг гахай

Махир хоёр соёотой
Маягийн хоёр чихтэй
Нарийн урт хумстай
Намхан богино хөлтэй...
Тариа төмс иддэг
Тарган хүчтэй гахай




.....
.....

3 Зургийг ажиглаад, өгүүлбэр зохиож бичнэ үү.



.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....





1 Урт ба хос эгшигтэй үгийг харьцуулан уншина уу.

-эй-

Өгөөдэй, Билгүүдэй хоёр ах дүү юм.
Өгөөдэй эрэгтэй, Билгүүдэй эмэгтэй.
Өгөөдэй дүүгээ бүүвэйлэв.

-уй-

Идэр дугуй унав.
Дугуй унах нь эрүүл мэндэд ач тустай.
Дугуй унах сайхан.

2 Эхийг уншаад, урт, хос эгшигтэй үгийг ялган бичээрэй.



Тоорой
Атигар жаахан биетэй
Адайр зөрүүд зантай
Тун ховдог сэтгэлтэй
Тоорой байж гэнэ.

Урт эгшигтэй үг	Хос эгшигтэй үг
.....

3 Урт эгшиг орсон үгийг уншиж, хос эгшиг орсон үгийг ялган бичээрэй.

Төмөр гуай айраг уух дуртай. Би унадаг дугуй авлаа. Хэрэмний сүүл сагсгар хар өнгөтэй, өтгөн байдаг. Голын усыг бохирдуулж болохгүй. Уулын мод урттай, богинотой. Олон хүн сайнтай, муутай.


.....
.....
.....
.....
.....

4 Богино эгшигтэй үгийг хос эгшигтэй үг болгон бичээд өгүүлбэр зохионо уу.

(ав- бур-, хар-)

.....
.....
.....

□□□□



1 Урт эгшигтэй үгийг богино эгшигтэй үг болгон бичээд, өгүүлбэр зохионо уу.

(Ээв-, саав-, хоол-)
.....
.....

2 Үндсэн ба туслах эгшгийг бичнэ үү.

Table with 2 columns: Үндсэн эгшиг, Туслах эгшиг. Below the columns are dotted lines for writing.

3 Зургийг нэрлэн бичээд, үндсэн эгшгийг будаарай.

Row of seven images: clock, tree, bow, yurt, wrestling, teeth, house. Below each image is a box for writing the name and a box for coloring.

4 Үндсэн эгшиг нөхөж бичээд, үг бүтээгээрэй.

сам . р , манж . н , болжм . р , сонгин . , хар . ндаа , зүл . г , хүр . м

5 Цэгийн оронд эгшиг үсэг нөхөж бичээд, цээжлээрэй. Ямар эгшгүүд нөхөж бичсэн бэ?


Намар

Ург . м . л бүхнийг х . таан
Усны ш . вууг б . цаан
Аял . нхан з . ныг х . лаад
Алт . н н ам . р ирд . г
С . ргуульд н . майг оруулж
Сур . гч болг . дог н . м . р
Амттай ж . мсийг болг . н
Ам дүүргэд . г нам . р



(Л. Түдэв)





1 Туслах эгшигтэй үг бичээрэй.

я- ямаа,
е- еэвэн,
ё- ёроол,
ю- юүлүүр,

2 Тохирох эгнээнд нь ялган бичээрэй.

түүе, амар, байшин, ялгаа, Юмжир, халбага, бяруу, оёо, алчуур, уулс

Үндсэн эгшигтэй үгс	Туслах эгшигтэй үгс
.....
.....

3 Холбоо үгсээр өгүүлбэр зохиогоорой.

Юндэн өвөө, юүдэн малгай, баян намар, ёотон хийх, бор еэвэн

.....
.....
.....
.....




4 Холбоо үгсээр өгүүлбэр зохиогоорой.

Юндэн өвөө, юүдэн малгай, баян намар, ёотон хийх, бор еэвэн

.....
.....
.....
.....





1 Өгүүлбэрийг уншаад, нүдлэн тогтоож, хуулан бичнэ үү.

Энэ манай морины уяа.
Янжин морио уяв.
Чи дээл оё.
Юмжир дээл оёв.

2 Шүлгийг цээжлээрэй.

Янзага

Янзага гэдэг нэртэй
Ямаа манайд байдаг юм
Ямбатай гэдэг нь жигтэй
Янзын хөөрхөн амьтан шүү


Хөгнө хааны магтаалаас

Есөн эрдэнийн баялагтай даа
Ерхөг хялгана халиурсан даа
Ерөөж магтаад баршгүй дээ
Ер бусын сайхан уул даа

3 Эхийг уншаад, утгыг ярилцаарай.

Зааны соёо

Заан халуун оронд амьдардаг.
Зааны тугал хөөрхөн. Заан урт
хоёр соёотой. Зааны соёогоор гоёл
чимэглэл хийдэг.




4 Үгийн сүлжээг бөглөн, ямааны идэх дуртай ургамлын нэрийг олцгооё.

1.			М	А	А	
2.	А	Й		А	Г	
3.			А	Л	У	У
4.	Н		У	Р		
5.	Ц	А				

1. Таван хошуу малын нэг
2. Гүүний сүүгээр хийсэн ундаа
3. Усны шувуу
4. Тогтмол ус
5. Идээний дээд





1 Хариуг зөв харгалзуулаарай. Тоог үгээр бичээрэй.

Хоёр хоёрын хэд вэ? 81

Есөн есийн хэд вэ? 4


2 Үлгэрийг уншаад, асуултад хариулна уу. Утгыг ярилцаж, ойлгосноо бичээрэй.

Зөрүүд ямаа

(Монгол ардын үлгэр)

Намрын хүйтэн өдөр байв. Гол дээр тавьсан нарийн гүүрийн хоёр талаас ухна иржээ. Тэд нэгийгээ хүлээж зам тавьж өгсөнгүй. Гүүрийн дунд хоёул уулзаж гэнэ. Бас л нэгэндээ зам тавьж өгсөнгүй. Уурласан хоёр ухна хоорондоо мөргөлдөв. Голын хүйтэн усанд хоёул пүл хийтэл унажээ.

- Хоёр ухна хаана уулзсан бэ?
- Яагаад усанд унасан бэ?
- Үлгэр ямар сургамжтай санаа байна вэ?



3 Хуулж бичээрэй.

Өмнөговь аймагт “Ёлын ам” гэдэг үзэсгэлэнтэй сайхан газар бий. Манай өвөөгийнх олон сайхан улаан ямаатай. Есдүгээр сарын нэгний өдөр хичээл эхэлнэ. Туяа их гоё юүдэнтэй цамц өмсчээ. Би еэвэн идэх дуртай.

Ямаа яргуйнд дуртай.

4 Зөв холбож, өгүүлбэр бүтээцгээе.

Ном
Хогоо
Тоглоом
Хаалгаа
Сүүгээ
Цонхоо
Машинаар


нээе.
уншъя.
хаая.
тоглоё.
хая.
зугаалъя.
хөөрүүлъя.

5 Эхийг уншина уу.

Еэвэн

Манай ангийн Юмжирмаа охин еэвэн зурав. Ийм еэвэн идэх юмсан гэж Ёндон санаа алдав.





1 Зургийг нэрлэж бичээд, эгшгийн үсгийн доогуур зураарай.



.....
.....
.....
.....
.....
.....

2 Шүлгийг уншаад, эгшиг үсгийн доогуур зураарай. Шүлгийг цээжлээрэй.

Ногооны зах дээр
Өнөр намар боллоо
Өргөн зах нээгдлээ
Шилэн мухлагаа онгойлгоод
Шинэхэн ногоогоо худалдахаар
Бөжин туулай ганцаараа
Бүтэн өдөржин ажиллалаа.

(Ч. Лувсандэндэв)



3 Хүснэгтийг ажиглаад, тохирох богино эгшгийг нөхөж бичээрэй.


хор	.	л
хур	.	л
хөр	.	г
хүр	.	м
хиш	.	г

дам	.	р
тэв	.	р
эв	.	р
төм	.	р
сур	.	г

4 Зүйр цэцэн үгийг хуулж бичээд, цээжилнэ үү.

Ахыгаа алд хүнд . л
Дүүгээ дэл . м хүнд . л
Олны ол . н тав . н цэн
Ажилч хүний ач арв . н
Эмч хүний ач арв . н

○ ○ ○ ○




1 Эхийг хуулж бичээд, утгыг ярилцаарай.

Ном

Эрдэнэ ном унших дуртай. Манай ангийнхан олон ном уншив. Мөрөн зурагтай ном авав. Сэлэнгэ үлгэр ярив. Булган номын санд байнга ном уншдаг.

.....
.....
.....
.....



2 Зургийг нэрлээд, тохирох эгшгийг нөхөж бичнэ үү.



Санд . л



цэц . г



болжм . р




гөл . г

3 Үгсээр өгүүлбэр бүтээцгээе.

1. Намар, хүйтэрнэ. цаг, агаар
2. навчис, Модны, шарлаж, газар, уналаа.
3. Хүн, бүр, дулаалж, дулаан, гэр, орноо, хувцсаа, бэлтгэнэ.

.....
.....
.....
.....

○ ○ ○



1 Эхийг уншиж, ярилцаад, хуулан бичигцгээе.


Туулайд урт чих ямар хэрэгтэй вэ?

Намрын ойд хүүхдүүд зугаалж явав. Нэг жаал бүрээ мэт зүйл бариад юм чагнаж байлаа. Хүүхдүүд сонирхон, түүнийг нь гуйж аваад, чимээ чагнав. Эндээс хот айл хүртэл нилээд хол байтал нохой хуцах, үхэр мөөрөх нь тод сонстоно. Тэгээд чихнээсээ холдуулмагц дүлийрсэн юм шиг зөвхөн шувуудын жиргэх, модны навчис унах чимээ л сонстож байлаа. Үнэхээр сонин юм аа.



Туулайд урт чих ямар хэрэгтэй болохыг эхтэй холбон тайлбарлаарай.

2 Амьтдын нэрийг бичиж сурцгаая.



3 Зөв өгүүлбэр болгон бичээрэй.

- болоход, буурна. нарны, Намар, илч
- тэнгэрт, Хөх, нар, алтан, мандаж байлаа.

.....
.....


4 Уншаад, утгыг ярилцъя.

Моносны нулимс

1. Монос яагаад уйлсан бэ?
2. Жимс түүхдээ модыг гэмтээж болох уу? Яагаад?

Манай ангийнхан “Хүүхэд байгалийн нөхөр” аялалд явлаа. Бид моносны төгөлтэй газар ирэв. Хүмүүс моносны дээд үзүүрт олсоор бугуйл шидэж, доош татахад мөчир тас няс хугарна. Гэтэл моносонд мойл байсангүй. Модны хугарсан мөчрөөс ногоон шүүс чив чив дусална. Энэ бол моносны нулимс юм.





1 Шүлгийг цээжилцгээе.

Навчис минь даарав уу?
 Мөчир мөчрөө орхин
 Шаргал навчис уналаа
 Мөр мөрөө даран
 Ийшээ тийшээ гүйлдлээ.
 ... Улбар хонгор навчис
 Даараа юм уу найзууд аа!
 Урагш хойш гүйлдээд
 Нөмөр хайв уу андууд аа!...



(О. Сундуй)

2 Уншаад, эр, эм эгшигтэй үгийг ангилан бичээрэй.

	Эр эгшигтэй үг	Эм эгшигтэй үг
Баяраа ойрдоо ажил ихтэй		
Байшин бариад амралт багатай
Өглөө босоод өрж гарна
Өндөр намаар нь барьж эхэлнэ

3 Эр эгшиг нөхөж бичээрэй.

Ш . р шувуу,

г . р х..руу,

Монг . л улс,

ар . г сав . р



4 Эгшгийг нь “О” эгшгээр сольж бичээд, уншъя. Өгүүлбэр зохиогоорой.

(цэг, цүнх, өнгөц,)


.....

5 Эм эгшгийн доогуур зураарай.

Цаас хэдий нимгэн ч
 Чичихээс нааш цоорохгүй

Уулын чимэг мод
 Улсын чимэг эрдэмтэн

○ ○ ○ ○ ○



1 Хүүхдүүдийн гарт байгаа тоог ашиглан гийгүүлэгчийн ангиллыг ярилцъя.



2 Тохирох үсгийг нөхөж, үг бүтээгээрэй. Ямар гийгүүлэгч үсгийн түлхүүр үг вэ?
Яагаад эгшигт гийгүүлэгч гэж нэрлэсэн бэ?

мон(...)ол баа(...)ар

(г, в)

..... гийгүүлэгч

3 Уншаад, гийгүүлэгч үсгийн доогуур зураарай. Ямар гийгүүлэгч үсгүүд багтсан байна вэ? Яагаад заримдаг гийгүүлэгч гэж нэрлэсэн бэ?

Цоожоо засаад тушаачих

..... гийгүүлэгч

4 Навчис минь даарав уу ?

Мөчир мөчрөө орхин
Шаргал навчис уналаа
Мөр мөрөө даран
Ийшээ тийшээ гүйлдлээ

.... Улбар хонгор навчис
Даараа юм уу найзууд аа
Урагш хойш гүйлдээд
Нөмөр хайв уу андууд аа


(О.Сундуй)



5 Үг бүтээж, илүүц үгийг олоорой .

нвач, мчөир, үднэс, назй





1 “Хэн олон үг нэрлэх бэ?” тоглоом тоглоцгооё. Ямар гийгүүлэгч үсгүүд орсон байна вэ?

“К” үсэг орсон үг хэлцгээе.

“П” үсгээр эхэлсэн хүний нэр хэн олныг нэрлэх бэ?

“Ф” үсэг нөхөөд, үг бүтээцгээе.

(...ерм, ...абрик, ...онд)

“Ц” энэ үсэг хаана хэрэглэгддэг бэ? Та нар мэдэх үү?

..... гийгүүлэгч

2 “Ногооны зах” сэдэвт эх зохиож ярилцаад, жимс ногооны нэрийг бичнэ үү. Эгшигт гийгүүлэгчийн доогуур зураарай.



.....
.....


3 Үгсийг оролцуулан өгүүлбэр зохиогоорой. Тодоор бичсэн гийгүүлэгчийг тохирох баганад бичнэ үү.

тариа, ногоо, лууван, навч, байцай, мод, жимс, ферм, кино

Заримдаг гийгүүлэгч	Эгшигт гийгүүлэгч	Онцгой гийгүүлэгч
----- -----	----- -----	----- -----

.....
.....
.....





1 Зүйр цэцэн үгсийн утгыг ярилцаад, гийгүүлэгч үгсийн доогуур зураарай.

Аавын хүү үг даадаг
Арвайн гурил ус даадаг

Аавын үгүйд ах нь аав
Ээжийн үгүйд эгч нь ээж

2 Эхийг уншаад, онцгой гийгүүлэгч үсэг орсон улсын нэрийг зураад, эхэд юуны тухай өгүүлсэн талаар ярилцаарай.

Онцлог ном

Японд үндэсний хоолны хэдэн зуун жортой нэг ном хэвлэгджээ. Тэр ном тун онцлог, хосгүй ном юм. Учир нь ямар нэгэн хоолны тухай бичсэн хуудсыг сэвэхэд хоолны үнэр нь ханхалдаг ажээ. Тийнхүү бүх хоолны үнэрийг номын хуудас бүрээс мэдэж болдог байна.



3 Цэгийн оронд тохирох эгшигт гийгүүлэгч үсэг нөхөж, үг бүтээгээрэй.

.	у	у		
у	.	с		
М	о	.	о	м
г	а	.	у	у
М	а	р	а	.


с	а	.	а	.
с	а	.	а	.
х	а	.	а	.
х	а	.	а	.
н	а		а	.

4 Цэгийн оронд С үсэг бичээд, харьцуулан уншиж, бичиж, үгийн утгыг ярилцаарай.

шар - ... ар
шор - ... ор
шир - ... эр
шил - ... эл

шөл - өл
шал - ... ал
шавар - ...авар,
шаваа -... аваа





1 Өгүүлбэрээс алдаатай бичсэн үгийг олоод, яагаад алдаатай гэж бодож байгаагаа тайлбарлаарай. Зөв болгож бичээрэй.

хүнсний дэлгүүрээс талх авна. Бид эрдэнэт хотод амьдардаг. Намайг болор гэдэг.

.....
.....
.....

2 Оноосон нэрийг олж дугуйлаарай.

- самар
- сургууль
- Баянгол
- дүүрэг
- Мөнх-Эрдэнэ
- анги

3 Эхээс хүний нэрийг олж бичээрэй.

Тэмцээн

Бид ангидаа тэмцээн зохиов. Энхээ, Батаа хоёр бөх барилдав. Оюунаа, Болороо, Ану гурав уралдав. Харин Хангал, Цэнгэл, Эрдэнээ нар шүүгч хийв. Бат-Эрдэнэ багш түрүүлсэн хүүхдүүдийг шагнав. Амараа тэмцээний үеэр зураг авлаа.




.....
.....

4 Дараах хүмүүст нэр өгч ярилцаад, өгүүлбэр зохиож бичицгээе.



.....
.....
.....
.....



1 Цэгийн оронд нэр бичээд, өгүүлбэр зохиогоорой.

Хүний нэр

Хотын нэр

Аймгийн нэр

.....
-------------------------	-------------------------	-------------------------

.....
.....
.....

2 Хүний нэрийн эхний үсгийг томоор бичдэг. Эхэд байгаа хүний нэрийг яаж бичсэнийг ярилцаад, хуулан бичээрэй.

Хэрэм

Бид ууланд аялах болов. Очир хамгийн урд туг барьж явав. Модон дундуур өөдөө өгсөж байлаа. Энд хэрэм байна гэж Энхээ хэлэв. Самар цөмж байгаа хоёр хэрэмний зургийг Оюун авч амжлаа. Би хэрэмний тухай шүлэг уншив.




.....
.....
.....
.....

3 Дараах өгүүлбэрийг гүйцээж бичээрэй. Хүний нэрийг яаж бичсэнийг тогтоож аваарай.

- Манай ангийн багш гоё бичдэг.
- Сурагч зураг сайхан зурдаг.
- Миний найз аялалд явах дуртай.
- хэрэмний зургийг маш гоё зурав.

Очир
Ундрал
Энхээ
Оюун



1

Хүүхдийн нэрийг ямар үсгээр бичсэн байна вэ? Цээжлээд, үйл явдлыг дүрслэн зурна уу.

Empty rectangular box for drawing.

Жигмид Тогмид хоёр

Жигмид Тогмид хоёр
Жимсэнд хамт явжээ
Уулын модонд очоод
Уралдаж түүхээр болжээ....
Түүсээр байгаад Тогмидын
Сав нь дүүрээд иржээ
Идсээр байгаад Жигмидийн
Гэдэс нь дүүрээд харьжээ...
(Д. Содномдорж)

2

Томоор бичсэн үгийг ажиглан тогтоож, юуны нэр болохыг ярилцаарай.

Өвөө


Миний өвөөг Балдан гэдэг. Өвөө минь Булган аймгийн Тэшиг суманд мал малладаг. Би зун болохоор өвөө, эмээ дээрээ очдог. Балдан өвөө улсын аварга малчин юм. Балдан өвөө тарган мал тал бүрийн ашигтай гэж сургадаг.



3

Асуултад хариулж бичээрэй.

- Чи ямар, ямар аймгийн нэр мэдэх вэ?
-
- Монгол улсад хэчнээн аймаг байдаг вэ?
-
- Танай аав ээж аль аймаг, хотод төрсөн бэ?
-
- Чи ямар, ямар хотын нэр мэдэх вэ?
-
-



1 Цэгийн оронд хүний нэр бичээрэй.

Миний хамгийн сайн найз бол Миний бага дүүгийн нэрийг гэдэг. Ангийн дарга тэргүүний сурагч юм. Сургуулийн захирал урлагийн үзлэгийн нээлтэд үг хэлэв.


2 Алдаатай бичсэн үгийг зөв болгож бичицгээе.

монгол улс ази тивд оршдог. Манай улсын нийслэл улаанбаатар хот юм. Хотын төв хэсэгт сүхбаатар дүүрэг байдаг. энэ дүүрэгт чингисийн талбай, сүхбаатарын хөшөө бий.


.....
.....
.....
.....

3 Хүүхдүүдэд тухайн үсгээр эхэлсэн нэр өгөөрэй. 3 өгүүлбэр зохиож бичээрэй.

- Бидний нэрийг хэн гэдэг вэ?





.....
.....
.....
.....



1 Дараах үеүдээр үг бүтээж уншаарай

ав	вөө	э	ө	мээ	дар
----	-----	---	---	-----	-----

2 Задгай үеэр төгссөн үгийг улаан өнгөөр будацгаая.

Эрдэмт хүн даруу	
Их мөрөн дөлгөөн	


3 Уншаад, битүү үеэр төгссөн үгийг хөх өнгөөр будаарай.

нагац, авга, ахмад, миний, атар, өргөн, аварга, цэцэг

4 Зургийг нэрлээд, тохирох эгнээнд нэрийг нь бичээрэй.



1 үетэй үг	2 үетэй үг	3 үетэй үг
.....



1 Уншаад, хоёр үетэй үгийг түүж бичээрэй.

Унасан морь чинь жороо бол
Унага даага чинь хурдан бол
Ухаан санаа чинь сэргэлэн бол



.....
.....
.....

2 “А, м, с, а, р” үсгүүдээр 1 үетэй, 2 үетэй үг зохиож бичээрэй.

1 үетэй үг	2 үетэй үг
Сар,	Самар,

3 Үеэр тасалж бичээрэй.


Амтат жимс түүх болов. Бид ууланд өдөр очлоо.
Арвин их жимс түүгээд, оройн нартай уралдаж
харилаа.



.....
.....

4 Үеэр зөв тасалсан үгийг олж, доогуур нь зураарай.

- сарм-аг-чин төг-өл-дөр хө-хөө-тэй
- сармаг-чин тө-гөл-дөр хөх-өөт-эй
- сар-маг-чин төг-өлд-өр хө-хөөт-эй



1 Эхийг уншиж ярилцаад, үеэр тасалж бичигцгээе.

Өвс тэжээл

Аав, ах хоёр хадланд гарав. Малдаа өвс
тэжээл авна. Хадсан өвсөө хатааж,
бухал хийнэ. Намрын шим тэжээлтэй
өвс өвөл, хаврын цагт их хэрэгтэй. Бид
удахгүй өвөлжөөндөө өвсөө татна.
.....

2 Хэн ? гэсэн асуултад хариулагдах үгсийг олж бичээрэй.

багш, манжин, эмч, самбар, мужаан, харандаа, хүүхэд



3 Юу ? гэсэн асуултад хариулагдах үгсийг нөхөж бичээрэй.

(оймс, шатар, ааруул, шувуу, хэрэм, бяслаг, цас)


Бат, Дорж хоёр (юу?) тоглов. Эмээ (юу?) нэхэв.
Малын сүүгээр өрөм, (юу?, юу?) хийдэг. Хавар болоход (юу?)
..... хайлдаг. (Юу?) нисдэг. Би ойд (юу?)
харсан.

4 Юу ? гэсэн асуултад хариулагдах үгсийг түүж бичээрэй.

цэцэг, Цэнгэл, навч, загас, салхи, сурагч, ширээ, халбага



.....
.....
.....
.....



1 Эхний үсгийг Я үсгээр сольж бичээд, уншаарай. Үгэнд асуулт тавиарай.

амаа, ангир, Одмаа, улаа, атга

.....

2 Зургаар холбоо үг зохиогоорой.



.....
.....
.....
.....

3 Загварт тохируулан өгүүлбэр зохиогоорой.

Хэн? уншив.

.....

Хэн? юу? уншив.

.....

4 Юу асуултад хариулагдах үгсийг түүж бичээрэй.


Элээ, хэрээ, галуу гурав
Ээрүүл, хайруул, хусуур гурав

.....
.....

5 Үгсийг ангилж бичээрэй.
зурах, цүнх, давхина, анги, гүйлээ, харина, Балжир, алхана, бүжиглэв, харлаа

Нэрлэсэн үг	Үйл үг
.....
.....
.....





1 Ерийн нэрэнд оноосон нэр өгөөрэй.

нохой- Банхар, Хүдэр

хот- Улаанбаатар,

улс- Орос,

2 Үсгүүдээр үг бүтээж, илүүц үгийг олж тэмдэглэнэ үү.

с, в, У	м, о, н	д, о, в, Х	о, г, д, Б	х, а, н, Д, а, р
.....

3 Холбоо үгсийг ашиглан өгүүлбэр зохиогоорой.

эх орон, миний ном, Туул гол

.....
.....
.....

4 Түргэн хэллэгийг цээжлээрэй. Холбоо үгсийг ялган бичээрэй.

Арын тэр нуур
Аргагүй том нуур

Авдрын тэр нүүр
Алаггүй хүрэн нүүр




.....
.....

5 Холбоо үгийг зөв харгалзуулаад, өгүүлбэр зохиож бичээрэй.

- | | |
|-------|-------|
| унь | тахь |
| ногоо | бахь |
| алх | тооно |
| алаг | тарь |

.....
.....





1 Үйлийг нэрлэсэн үгийн доогуур зурна уу.

Хүүхдүүд элсэн дээр тоглов. Эгч хөгжим тоглолоо. Эмээ оймс нэхнэ. Аав хоол хийлээ.

Амар ном уншлаа. Бид цэцгээ услав. Дүү навч түүв. Алимаа ойд зугаалав.

2 Үйлийг нэрлэсэн үгэнд асуулт тавиарай.

(.....?) (.....?) (.....?)
Навчаа хөгжим тоглоно. Эмээ гэрээ цэвэрлэв. Ээж дүүд хоол өгсөн.

3 Цэгийн оронд үйлийг нэрлэсэн үг бичиж, өгүүлбэр бүтээгээрэй.

Мод Т.....
У.....
Ү.....

4 Зөв хариултыг тэмдэглээрэй.

1. Үйлийг нэрлэсэн үг ямар гэсэн асуултад хариулагдана.
2. Үйл үг хэн, юу асуултад хариулагдана.
3. Үйл үг яав, яаж байна, юу хийж байна асуултад хариулагдана.

5 Зураг дээр дүрслэгдсэн үйлийг үгээр илэрхийлж бичээрэй.




.....

.....

.....

.....

.....



1 Онсогыг таана уу. Үйл хөдлөл заасан үгийг нэрлээрэй.

Цагаан торгыг
Эвхэж барахгүй.
Тэр юу вэ? Яагаад? (ц..)

2 Өгүүлбэр зохиож, утгыг тайлбарлан ярилцаарай.

Би ном унш

- сан.
- даг.
- лаа.
- в.
- на.

Дүү тоо бод

- сон.
- лоо.
- жээ.
- в.
- но.

3 Хооронд нь харьцуулж, ижил ба ялгаатай талыг ярилцаж, үйлийг нэрлэсэн үгийг бичнэ үү

.....
.....
.....



.....
.....


4 Тохирох үгсийг зөв холбож, өгүүлбэр зохиогоорой.

Цас
Нохой
Болжмор
Хүүхдүүд
Тахиа

донгодно.
цасаар тоглов.
хуцаж байна.
орлоо.
жиргэнэ.

.....
.....
.....
.....

○ ○ ○ ○



1 Асуултад хариулж бичээд, үйлийг нэрлэсэн үгийг тодотгоорой.
(гулгаж, өвлийн өвгөн, хөлдөв)

- Гол мөрөн яав?
- Хүүхдүүд мөсөн дээр яаж байна?
- Хүүхдүүд цасаар юу хийсэн бэ?



.....
.....

2 Өгүүлбэр зохиож уншиж, бичнэ үү.



уу

Оюунаас



асуу.

.....
.....

3 Цэгийн оронд тохирох үгсийг нөхөж бичээрэй. Өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Өгүүлбэрийг ... үсгээр эхлэн бичдэг.

Өгүүлбэрийн төгсгөлд ... тавьдаг


4 Өгүүлбэрт ямар алдаа байна вэ? Зөв болгож бичээрэй.

тэмээний төлийг ботго гэдэг

өдөр уртсаж, дулаан болно

өвс ногоо ургана





1 Зөв өгүүлбэр болгон бичээрэй.

- зугаалъя. Ой модонд
- Найз нартаа тусалъя.
- үүр засъя. Шувуунд
- уншъя. Ном сонин

2 Өгүүлбэрийг загварын дагуу дэлгэрүүлж бичнэ үү.

- | | |
|--------------------------|-------------|
| Болд зурав. | Бид бодлоо. |
| Болд мод зурав. | |
| Болд царс мод зурав. | |
| Болд том царс мод зурав. | |

3 Уншаад, хэдэн үгнээс бүтсэн өгүүлбэр болохыг хэлээрэй.

Ах ирлээ. (.....) Ах цай уув. (.....) Ах ном сонин уншив. (.....)

4 Зургаар асуух өгүүлбэр зохиогоорой.




.....
.....
.....
.....
.....

5 Хүүрнэх өгүүлбэрийг асуух өгүүлбэр болгон бичээрэй.

Хүүрнэх өгүүлбэр

Асуух өгүүлбэр

- | | |
|---------------------------|-------------------------|
| Эгч хотоос ирсэн. | - Эгч хаанаас ирсэн бэ? |
| Дүүд энэ ном байдаг. | - |
| Аав дэлгүүрээс талх авав. | - |
| Эгч аяга, тавгаа угаасан. | - |



1 Эхийг уншиж, утгыг ярилцаад, хуулан бичээрэй.

Хүүхэд шувуу хоёр

Сэргэлэн цовоо хүүхэд багачуудын гараар бүтдэг ажил үйлс олон. Түүний нэг бол жил бүрийн дөрөвдүгээр сарын нэгэнд болдог жигүүртэн шувуудын баяр юм. Энэ баяраар хүүхдүүд шувуунд үүр барих ажил хийдэг. Хүүхдүүд ээ! Шувуунд үүр барьцгаая.



2 Зургаар эх зохион ярилцана уу.




3 Эхийг уншаад, асуултын дагуу ярилцъя.

Бороотой үед нар, сар хаашаа орчихдог вэ?

Бороо бол үүлнээс дусах дусал гэдгийг бид бүгд мэднэ. Хэрэв үүл байхгүй бол бороо хаанаасаа орох сон билээ. Бороо орох үед үүл маш зузаан, нягт байдаг учир нарны гэрэл түүгээр нэвтэрч чадахгүй. Иймээс бид нар, сарыг харж чаддаггүй. Тэд биднээс нуугддаггүй, зүгээр л үүлний цаагуур ордог ажээ. Бороо зогсож, үүл нүүхэд бид нар, сарыг дахин харах болно.

- Ямар улиралд бороо ордог бэ?
- Бороотой үед нар, сар хаашаа орчихдог бэ?
- Хүйтний улиралд бороо ордог уу? Яагаад?





1

Зураг ашиглан, асуултын дагуу эх зохион бичээрэй.



- Ямар улирлыг харуулсан зураг байна вэ?
- Байгалийн ямар өөрчлөлтийг бид зургаас харж болох вэ?
- Хүүхдүүд яаж хувцасласан байна вэ?
- Яагаад навч унадаг вэ?

.....

.....

.....

.....

2

Эхийг уншаад, утгыг ярилцаарай. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодорхойлж, өнгөөр ялган будаарай.


Навч яагаад унадаг вэ?

Намар болоход ургамлын навч аажим шарлаж хагдарна. Зарим ургамлын навч унадаг. Яагаад?

Намар нарны илч буурч, хүйтэн сэрүүн болоход навчийг ногоон өнгөтэй болгодог мөхлөг нь задардаг. Навчны эсийн дотор улаан шар өнгөтэй будагч бодис үлдсэнээс навч улайх, шарлах зэргээр хувирна.

Хүйтрэхэд ургамал хөрснөөс ус бага авдаг учир навч хөгширдөг. Энэ үед навчны эсэд ургамлын амьдралд хэрэггүй эрдэс давс их хэмжээгээр бий болж, навч унадаг байна.





1

“Жилийн 4 улирал” сэдэвт зураг зурна уу.

Large empty rounded rectangle for drawing.

2

Эхийг уншаарай. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг олж тэмдэглээрэй.

Цас юунаас бүтдэг вэ?

- Найзаа! Цас юунаас бүтдэг юм бэ?
- Цас уу, энэ чинь өчүүхэн талст мөс, агаар хоёроос бүтдэг юм гэнэ билээ.
- Тийм гэж үү?
- Тийм ээ. Чи шинэхэн цасаар хувингаа дүүргээд үз. Тэгээд хайлуул. Хувингийн чинь ёроолд жаахан ус л үлдэнэ дээ. Арван литрийн хувин дүүрэн цас ердөө л ганц литр ус болчихно. Тэгэхлээр цасны ганцхан жаахан хэсэг нь л ус, бусад нь агаар байна гэсэн үг юм даа. Ойлгов уу?
- Ойлголоо. Баярлалаа.




3

Холбоо үгсийг оролцуулан эх зохиож бичээрэй.

Дулаан болох, урт өдөр, богино шөнө, өвс ногоорох, усны шувууд ирэх, мал төллөх

Four horizontal dotted lines for writing.

Three empty circles for rating.



1

Шүлгийг уншаад, “Нохойн хошуу” сэдэвт эх бичээрэй.

Нохойн хошуу

Гоёж будсан юм шиг

Яв ягаан цэцэгтэй

Оёж шидсэн юм шиг

Ясан бөөрөнхий үрэлтэй

Энэ нохойн хошуу

Эх орны баялаг

Зорьж ирсэн юм шиг

Өндөр туяхан иштэй

Зориуд шигтгэсэн юм шиг

Өргөсөн шиврээ сахалтай

Энэ нохойн хошуу

Эмийн ургамал

(Т.Алтанцэцэг)



.....
.....
.....
.....
.....
.....

2

Эхийг уншаад, утгыг ярилцаарай. Асуулт зохиож бичээрэй.


Үнэг үлгэрийн юм шиг амьтан

Үнэг бол хаа сайгүй байдаг, хамгийн их танигдсан нохойн төрлийн араатан. Хээнцэр гоо үзэмжтэйн зэрэгцээ муу нэр, луу данстай. Дэлхийн олон орны ардын аман зохиолд үнэг гол баатраар тодорч, сайн муугаар яригдах нь олон.

Үнэг хүнтэй ойр амьдарч, бас хэнээс, юунаас айхаа сайн мэднэ. Занга өгөөшийг аргалж дөнгөнө. Мөрөө ч баллаж чадна. Гэвч хүний төсөөлдөг шиг тийм ч зальтай, болгоомжтой амьтан биш.

Гагцхүү сониуч зан нь сонор сэрэмжтэй байдлыг нь ямагт ялан дийлж байдаг л хэргийн учир байгаа юм.-

.....
.....
.....
.....



1 Эхийг уншаад, харилцан ярилцаарай.

Би номонд дуртай.

Ном болгон надад ертөнцийг бага багаар нээн үзүүлж, амьдралыг танин мэдүүлж байжээ. Номын утга, түүний баатрууд, үйл явдал толгойд минь цуглаж, намайг эрхэндээ бүрэн оруулсан. Надад муу ном гэж нэг ч байгаагүй. Номтой нөхөрлөсөн минь надад их тус болж, амьдралын минь сургууль болсон. Ном миний авьяас, ухааныг минь нээж өгдөг.

(До.Содномдорж)

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг хуулан бичээрэй.

.....
.....
.....
.....




2 Эхийг уншиж, утгыг ярилцаад, “Миний эх орны байгаль” сэдэвт зураг зурцгаая.

Байгаль хамгаалах ёс

Хүн байгаль хоёрыг хүйн холбоотой гэж үздэг. Манай өвөг дээдэс байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, унаган төрхөөр нь байлгахын тулд эрт дээр үеэс уламжлан ирсэн мөнх хөх тэнгэр, уул ус, байгаль дэлхийгээ тахиx, шүтэх зэрэг олон зан үйлийг хийсээр ирсэн. Байгалийн баялгаа зүй зохистой ашиглах нь бидний эрхэм үүрэг билээ.

.....



1 Эхийг уншаад, харилцан ярилцаарай.

Пингвин

Пингвин бол өмнөд туйлд амьдардаг шувуу. Энэ шувууны өвчүү цээж нь цагаан, нуруу нь хар байдаг. Пингвин далавчтай боловч нисдэггүй. Харин усанд сайн сэлдэг. Пингвин загасаар хооллодог. Пингвинийг монголчууд оцон шувуу гэдэг.

- Пингвин хаана амьдардаг вэ?
- Пингвин ямар шувуу вэ?
- Монголчууд энэ шувууг юу гэж нэрлэдэг вэ?

2 Жилийн дөрвөн улирлын талаар эх зохиож бичээрэй.



- Ямар улирал болж байна вэ?
- Улирал бүрд байгалийн ямар өөрчлөлтүүд болдог вэ?
- Аль улиралд чи дуртай бэ? Яагаад?

.....


.....

.....

3 Үлгэрийг уншаад, үргэлжлүүлэн зохиож яриарай.

Алт Мөнгө хоёр /монгол ардын үлгэр/

Эрт цагт Алт, Мөнгө нэртэй ах дүү хоёр байжээ. Хоёр хүү холын уулнаас мод түүхээр явжээ. Ээж нь хоёр хүүдээ замдаа идэж яв гэж нэг, нэг боодолтой ааруул эзэгий өгөөд, "хоорондоо эвтэй яв, ах нь дүүгээ асарч яв" гэж захижээ. Их хүйтэн, цасан шуургатай шөнө хоёр хүү хээр хонох болжээ. Ингээд хоёулаа хоёр тийш явж, агуй хайхаар болов...




.....

.....

.....

.....



1 Эхийг уншиж ярилцаарай.

Тэмээн сүрэг

Говьд тэмээ их байдаг. Тэмээний төлийг ботго гэдэг.
Тэмээний ноос зөөлөн, дулаан.
Сүү нь тослог, өтгөн. Манай өвөө тэмээ малладаг.



- Хаана олон тэмээ байдаг вэ?
- Тэмээний ноос ямар вэ?
- Сүү нь ямар вэ?
- Тэмээний төлийг юу гэдэг вэ?

2 Эхийг уншаад, “Миний дүү” сэдэвт эх зохион бичээрэй.

Дүү

Намайг Дондог гэдэг. Би нэгдүгээр ангид сурдаг. Миний дүү
Дөлгөөн их хөөрхөн.
Дөлгөөн олон дуу мэддэг. Дүү минь намайг хүндэлдэг.



.....
.....
.....
.....

3 Эхийг уншаад, “Онон” гэсэн үгэнд хэн, юу? асуулт тавьж, бичээрэй.

Онон


Энэ миний найз Онон. Онон номхон дөлгөөн зантай. Онон үнээ саана.
Энэ голын нэр бас Онон. Онон гол ширүүн урсана.


1. нэр
2. нэр

4 Эхийг уншаад, ойлгосноо зурж үзүүлээрэй.

Парк

Хүүхдийн баяраар бид паркад очив. Паркад олон шинэ тоглоом байдаг. Бид паркад очиж тоглох дуртай. Бид алсыг харагч дээр суув. Алсыг харагчаас бүх зүйл сайн харагддаг. Бид удаан тоглов. Бид хөгжилтэй, зугаатай байлаа.





1 Эхийг уншаад, “Шагай” сэдэвт эх зохиож бичээрэй.

Морин хуур
Хасар морин хуур хөгжим сурав. Монгол хүн бүр морин хуур хөгжмөө дээдэлдэг. Гэрийн хойморт морин хуур хөгжмөө залдаг. Бид морин хуураар тоглов.

Шагай
.....
.....
.....
.....

2 Харьцуулан уншаарай. Талх яаж хийдэг болохыг ярилцагсаая.

Тариа будаа

Тариа будаа хоёрыг

Тарьж ургуулдаг юм

Тарьсан хойноо түүнийг

Хурааж авдаг юм

Тансаг сайхан тариагаа

Гурил болгож тээрэмдээд

Та бидний иддэг

Талх боовыг хийдэг юм

(Н.Цэдэвсүрэн)

Талх

Талх хийхийн тулд тариа тарих хэрэгтэй.

Тариа тарихдаа эхлээд үрээ сайн сонгоно. Үр

болгоныг соёолуулах хэрэгтэй шүү. Тэр нь

тариа болон ургана. Ургасан хойно нь хураан

авна. Хураан авсан тариаг гурилын үйлдвэрт

тээрэмдээд гурил болгоно. Ингээд гурилаараа

талх боов хийдэг.

3 Онъсогыг таагаарай. Тааврын хариугаар “Хүнсний ногоо” сэдэвт эх зохион бичээрэй.

Дээрээс харахад

Дэрэвгэр ногоон

Дэргэд нь очиход

Бөндгөр ногоон

Тэр юу вэ? Яагаад? (б.....)

Бутан дотор

Бумбагар хүүхэд

Тэр юу вэ? Яагаад? (т...)

Нарийн улаан хүүхэн

Газар доор сууна

Намирсан ногоон алчуур нь

Газар дээр дэрвэнэ

Тэр юу вэ? Яагаад? (л.....)


Нүцгэн биеий нь харвал

Нүдний нулимс гоожино

Тэр юу вэ? Яагаад? (с.....)

.....
.....
.....
.....





1 Эхийг уншаад, асуултад хариулна уу?

Мод тарьцгаая.

Мод тарих нь эрүүл мэндэд нэн тустай. Мод тарихад хар шороо, элс, хөх бууц хийж хөрсөө бэлдэнэ. Бэлдсэн хөрсний гол хэсэгт модныхоо үндсийг байрлуулж, шороогоор чигжиж өгнө. Дараа нь модоо сайн усалж, арчилбал бидний эргэн тойрон ногоон ойтой болно шүү. Хүүхдүүд ээ! Мод тарьцгаая.



- Мод тарих хөрсийг хэрхэн бэлтгэх вэ?
- Модыг яаж арчлах вэ?
- Мод ямар ашиг тустай вэ?

2 Харьцуулан уншаад, өөрийн үгээр эх зохион бичээрэй.

Мойл

Туул голын шугуйд
Монос мод найгана
Туяхан нарийхан ишинд нь
Мойл жимс бөнжийнө
 Үрлэн хүрэн жимсийг нь
 Атгаад авах гэхлээр
 Үй түмэн өргөс нь
 Хатгаад болдоггүй хяслантай
Жимс өргөс хоёр
Зэрэгцэн ургах л юм даа

Мойл

Туул голын шугуйд монос мод элбэг байдаг. Монос модонд мойл жимс ургана. Мойл жимс хар хүрэн өнгөтэй, үрэл шиг бөөрөнхий хэлбэртэй. Мойл жимсийг түүхэд төвөгтэй. Жимсний мөчир нь өргөстэй байдаг. Мойлыг хатааж эмчилгээний болон хүнсний зориулалтаар ашиглана.


Т.Жамьянсүрэн

.....
.....
.....
.....

3 Зүйр цэцэн үгсийн утгыг ярилцаад, өөртөө таалагдсан хэсгээ хуулан бичээрэй.

Ажил хийвэл ам хөдөлнө
Алхайж суувал амьдрал доройтно
 Ажил хийж хүн болдог
 Ар давж хүлэг болдог
 Ажил хийсэн нь амандаа тостой
 Ажилгүй суусан нь амандаа устай
 Ажилч хүн амны хишигтэй
 Залхуу хүн заяа муутай

○○○



1 Эхийг уншаад, утгыг ярилцаарай. Асуултад хариулж бичээрэй.

Цай

Үндэстэн бүр өөрийн онцлогт тохирсон цай хэрэглэдэг. Монголчууд цайг эрхэмлэн дээдэлдэг. Цай хүний эрүүл мэндэд тустай. Манай ард түмэн сүүтэй цай их уудаг. Би борцтой, будаатай, хийцтэй цайнд дуртай.

- Чи ямар цайнд дуртай вэ?

-

2 Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээд, эхийг гүйцээгээрэй.

Уулс

(Богд, Баянзүрх, Чингэлтэй, Сонгино)

Манай хот дөрвөн сайхан уулсын дунд оршдог. Хотын урд хэсэгт дархан цаазат уул сүндэрлэн байдаг. Зүүн талд хайрхан, баруун талд хайрхан, хойт талд хайрхан оршино.

Манай ард түмэн уул усаа тахиж шүтэж ирсэн билээ.



3 Эхэд гарчиг өгөөд, ялгааг нь ярилцаарай.

.....

- Алтан нар, алиман сарны аль нь өглөө эрт манддаг вэ?

- Алтан нар нь өглөө манддаг, алиман сар нь шөнө гардаг.

4 Эхийн уншаад, ярилцаарай. Асуултад хариулж бичээрэй.

Заг говьд ургасны учир

(Үлгэр)

Эрт дээр үед хар мод, заг хоёр эвтэй найртай зэрэгцэн ургадаг байсан гэдэг. Нэгэн удаа хар мод, заг хоёр маргалджээ. Заг хэлэхдээ:

-Би бол хөрсний усаар биш нарнаас илч авч ургадаг гэв. Шинэс хэлэхдээ:

-Ус бол хамгийн үнэт эрдэнэ мөн гэжээ.

Усыг үл ойшоон, нарыг магтсан заг говьд ургах болжээ. Усыг магтан гэрлийг үл ойшоосон хар мод нь уулын ар, сүүдэр газар ургадаг болжээ.


-Хар мод хаана ургадаг вэ?

-.....

-Заг хаана ургадаг вэ?

-.....





1 Эхийг уншаад, ярилцаарай. Асуултад хариулж бичээрэй.

Гацуур

Ой тайгад ургадаг мөнх ногоон шилмүүстэй модыг гацуур гэнэ. Гацуур зөөлөн, хөнгөн жинтэй учир гэрийн тавилга, морин тэрэг хийхэд зохистой. Мөн цаас, торго, даавуу хийдэг. Монголчууд дээр үеэс гацуураар шилмүүст рашаан хийж, эмчилгээнд хэрэглэж иржээ. Гацуур мод нь өвөл, зунгүй мөнх ногоон байдаг.



-Гацуураар гоёдог ямар баяр байдаг вэ?

.....
.....

2 Шүлгийг уншаад, “Манай гэр бүл” сэдэвт эх зохиож бичээрэй.

Манай гэрийнхэн

Аав ээж ах эгч бид нар ойд очив.
Аав ээж асар том агар хувин жимс түүв.
Ах эгч арай багахан саваа бас дүүргэв
Харин би хамгийн жижиг саваар жимс түүлээ.
Г.Жамъянсүрэн

.....
.....
.....

3 Эхийг уншаад, ярилцаарай. Асуултад хариулж бичээрэй.

Монгол орон

Монгол орон хавар, намар, зун, өвөл гэсэн жилийн дөрвөн улиралтай. Хангай, говь хосолсон үзэсгэлэнт сайхан орон юм. Орхон, Сэлэнгэ, Онон, Хэрлэн зэрэг томоохон гол мөрөн бий. Өвс ургамал, ан амьтан, ашигт малтмалаар элбэг баян билээ.

-Дөрвөн улирлыг нэрлэж бичээрэй.

.....

-Хамгийн дулаан улирлыг нэрлээрэй.


.....

-Ямар улирал хамгийн хүйтэн байдаг вэ?

.....

-Ямар, ямар гол мөрөнг мэдэх вэ?

.....



1

Хэл зүгшрүүлэх үгсээ тогтоож хэлээрэй.

Дадах – татах Дайрах – тайрах Далбаа – талбай Догол – тогло Дуу – туу Дээвэр – тээвэр Зай – цай Зуу – цуу	Өглөө – үглээ Өргөдөг – үргэдэг Цангаах – чангаах Цэг – чиг Замаар – чамаар Зангадах – чангадах Эгч дуулаад Эгц уул өөд авирав
Хушуу, хуруу, эрүү гээд Хушуу, хуруу, эрүүгээ Бушуу өөрөө заагаарай	Туурай туруу хоёрын Аль нь адуунд Аль нь үхэрт байдаг вэ?
Дээлийн хээтэй торго Дэлэм хэртэй хөөрөг	Залгиж идвэл хор болно Зажилж идвэл хоол болно
Бөв бөөрөнхий Бөндгөр бөмбөгийг Бөв бөөрөнхий Бөндгөр бөөрөөр нь Бөмбөрүүлэн бөмбөрүүлэн өнхрүүлнэ.	

2

Ертөнцийн гурвыг сонголтоороо цээжлээрэй.

Ертөнцийн гурван хурдан

Салхит тэнгэрийн үүл нэг хурдан
Саруул ухаантны санах нэг хурдан
Сайн морины давхих нэг хурдан

Ертөнцийн гурван шар

Эрдэнэд алт нэг шар
Эдэд жанч нэг шар
Идээнд уураг нэг шар

Ертөнцийн гурван цовоо

Ой сайтай хүн нэг цовоо
Онгон талын туурайтан нэг цовоо
Онц сурдаг хүүхэд нэг цовоо

Ертөнцийн гурван муу

Ахмадын үгийг сонсдоггүй бол нэг муу
Аав ээжээ асардаггүй бол нэг муу
Ажил хөдөлмөр эрхэлдэггүй бол нэг муу

Ертөнцийн гурван том

Оосор бүчгүйгээс орчлон том
Оосор оломгүйгээс далай том
Орой хязгааргүйгээс огторгуй том

Ертөнцийн гурван дутуу

Уул бүслүүргүй нэг дутуу
Далай таглаагүй нэг дутуу
Тэнгэр баганагүй нэг дутуу

Ертөнцийн гурван олон

Худалч хүний нээрээ олон
Хуурамч хүний хөөрхий олон
Хуудуу хүний за олон


Ертөнцийн гурван байна

Ус байваас замаг байна
Уул байваас зам байна
Ухаантан байваас засаг байна

Ертөнцийн гурван байх

Уул хэдий өндөр боловч оргилтой байх
Далай хэдий гүн боловч ёроолтой байх
Тал хэдий уудам боловч хөвөөтэй байх





1

Шүлгийг цээжлээд, уран тод уншиж сураарай.

Дөрвөн улирал

Хүүхэд бидний
Баяр болдог
Хөгжөөнт зуны
Улирал сайхан

Амтат жимсээр
Бэлэг барьдаг
Алтан нмар
Ай даа гоёхон

Сүлд модны
Наадам болдог
Сүртэй өвөл
Бас гайхам

Зун, намар, өвлийн
Зугаатай бүгдийг нь дуурайсан
Содон чамин хавар маань
Сайхан, гоёхон, гайхам.

- Жилийн дөрвөн улирлыг нэрлэнэ үү ?
- Ямар улирал болж байна вэ ?
- өвлийн улирал юугаар онцлог вэ ?



Намираа бороо орж
Навч цэцэг дэлгэрэн
Нарийн голд очиж
Наадаж бид шумбана
Дэгдэн дэгдэн явж
Дэнжийн цэцэг түүнэ

Зун

Эргэн тойрон гүйж
Эрээн эрвээхий барина
Өгөөмөр баян зуны
Өдөр бүр нь сайхан
Өвөөлж, хөхөө донгодоод
Өөлж баршгүй сайхан аа
Д.Маам

Намар

Навчит модны шуугисан чимээ
Нарийн хурын шаагисан авиа
Царцаа дэвхрэгийн цар цар дуу
Цагийн хувирлыг бидэнд зарлана
Хар улаан товчтой жимээр
Хад аньс мойл жимсэнд
Найгасан өтгөн өвс ногоонд
Намрын сайхан амт шингээстэй
Ч.Лхамсүрэн




Өвөл

тэртээ уулын энгэрээр
Цаначин хүүхдүүд уралдана
Тэднээс хоцрохгүй гэсэн шиг
Чаргаар зарим нь зэрэгцэнэ
Өндөр уулын өврөөс
Өвлийн жавхааг үзлээ
Багачууд хүүхдүүдийн дуунд
Байгаль тэгш сэргэлээ.

Д.Давааням





1

Хавар

Хундан хонь минь хавар хургалдаг
 Ургамлын түрүү хавар ургадаг
 Хамаг идээ хавар дэлгэрдэг
 Хүрэгч гүү минь хавар унагалдаг
 Хув зусаг минь хавар ишиглэдэг
 Хавар хавар ханагархан хавар
 Усны шувууд хавар ирдэг
 Хайртай ингэ минь хавар ботголдог
 Хүрэн үнээ минь хавар тугалдаг
 Хайрлан ханашгүй хавар



Д.Маам

2

Загварын дагуу хувиргаж, эх зохиож бичнэ үү.

Зун

Жилийн хамгийн дулаан улирал зун юм.
 Өдөр нь урт, шөнө нь богино байдаг. Өдөрт
 нь урт, шөнө нь богино байдаг. Бороо орж,
 цэцэг навч дэлгэрдэг. Хүүхдүүд зусланд
 явж, зугаатай амардаг. Ан амьтан,
 шувуудын хоол, тэжээл элбэг болно.



Өвөл

.....

.....

.....

.....

.....

.....


3

Асуух өгүүлбэрт бүтэн өгүүлбэрээр хариулж бичицгээе.

Зун

- Ямар улиралд чи илүү дуртэй вэ ?
- Ямар улиралд цас ордог вэ ?
- Яагаад өвлийн улиралд дулаан хувцас өмсдөг вэ ?
- Аль улиралд цана, чаргаар гулгадаг вэ ?

- Би өвлийн улиралд дуртай.



1

Шүлгийг цээжлээд, уран тод уншиж сураарай.



*Хэрэм
Соотойсон чихтэй
Сормойсон нүдтэй
Сагсайсан сүүлтэй
Сааралхан хэрэм*



*Зараа
Арзайсан хуягтай
Бөрзийсөн зүстэй
Шөмбийсэн хошуутай
Бөөрөнхий зараа*

2

Хөгжүүлэх дасгалын хувилбарууд:

“Амин дэм” шүлэг

Улаан лууван
Шар манжин
Ногоон сонгино
Навсгар байцаа

Бултаараа амттай
Амин дэм
Бүгдээрээ ашигтай
Амин дэм

3

Илүүц үгийг олцгооё. Яагаад илүүц вэ? тайлбарлана уу.

сүү

манжин


ааруул

врэм

4

Илүүц зургийг олоорой. Яагаад илүүц вэ? тайлбарлаарай.





1

Ямар ногоонд ямар амин дэм байдаг вэ? Уншаад, утгыг ярилцаж, асуултад хариулж бичээрэй.

Төмс

Хамгийн түгээмэл хэрэглэгддэг хүнсний ногоо юм. Төмсөнд хүний биед хэрэгтэй цардуул, С аминдэм ихээр агуулна.



Лууван

Лууван нь хамгийн амттай ногооны нэг. Луувангийн шүүсэнд бид дуртай. Лууванд А, С амин дэм ихээр агуулагддаг. Ялангуяа хараа сайжруулах ач тустай ногоо шүү.



Байцаа

Байцаа нь хүний ходоод гэдэсний үйл ажиллагааг идэвхжүүлэх ач тустай хүнсний ногоо юм.



Сонгино

Сонгино нь найрлагадаа олон төрлийн амин дэм (А, В, С, Д, В1, В6, РР) агуулдаг. Үрэвсэл болон вирусний эсрэг үйлчилгээтэй, дархлаа дэмждэг.



.....
.....
.....
.....

2

Онъсогыг таацгаая.


Бутан дотор
Бумбагар сурагч (төмс)

Нүцгэн биеийг нь харвал
Нүдний нулимс гоожно (сонгино)

Дээрээс нь харахад
Дэрэвгэр ногоон
Дэргэд нь очиход
Бөндгөр ногоон (байцаа)

Нарийн улаан бүсгүй
Газар доор сууна
Намирсан ногоон алчуур нь
Газар дээр дэрвэнэ (лууван)





1

Эхийг уншаад, ярилцаарай.

Мод таригч өвөө

.... Манай сумын төв их талын дунд оршино. Сумын төвийн гудамж талбай байшин барилга эргэн тойронд мөнх ногоон гацуур, мөнгөн цагаан хус, алтан хонгор улиас ургана. Энэ их олон мод бут аяндаа ургаа юу гэвэл үгүй. Тэднийг манай нутгийн Марзан шовгор хэмээх өвөө тарьж ургуулсан юм. Аав маань : “Намайг бүр жаахан хүүхэд байхад л ийм шомбогор шар өвгөн байсан. Огт өтлөхгүй сонин хүн юм даа” гэж гайхна.



О.Сундуй

2

Асуултад хариулж бичээд, балархай эгшгийг доогуур зураарай.

- Сумын төвийн эргэн тойронд ямар, ямар мод ургасан бэ ?
- Модыг хэн тарьсан бэ ?
- Өвгөнийг нутгийнхан хэн гэж дууддаг байсан бэ ?
- Аав нь өвгөний тухай юу гэж хэлсэн бэ ?

3

Эхээс урт, хос эгшиг орсон үгийг түүж бичээд, авиа үсгийг тодорхойлно уу.

Жишээ нь : цэлийх – 6 үсэг, 5 авиа

хөдөөгийн – 9 үсэг, 7 авиа

4

Өгүүлбэр зохион бичээрэй.

Сарнай,

Ган-Очир Молом,


5

Урт эгшиг нөхөж бичнэ үү.


Мин .. өв олон мод тарьсан.

Дууссан: он сар өдөр.....цаг

Өөрийн үнэлгээ:



1 Зургийг ажиглан, цэгийн оронд тохирох үгийг гүйцээн бичээрэй.



Гэрлэн дохио

Гэрлэн дохио бол замын хөдөлгөөнийг зохицуулна. гэрлээр явж болно. гэрлээр явж болохгүй. Гэрлээр зогсож хүлээнэ. Гарцын шугамтай газар, гэрлэн дохиогоор зам хөндлөн гарах нь хүн бүрийн үүрэг мөн.

2 Шүлгийг цээжлээрэй. Гэрлэн дохио зөрчлөв ямар аюул учирч болох вэ ?

Гэнэдэж битгий гүйгээрэй

- | | |
|----------------------------|--------------------------|
| Гурван өнгийн гэрэл | Шар гэрэл бүгдийг |
| Замын хөдөлгөөн зохицуулна | Шалгаж зогсоох учиртай |
| Гурвуулаа зэрэг асахгүй | Улаан гэрэл зөвхөн |
| Цуварч гэрэлтэх нь учиртай | Урагшаа явахыг хориглоно |
| Ногоон гэрлээр хүүхдүүд | Зам гарахдаа багачууд аа |
| Тайван алхалж болно | Заавал мэдэж аваарай |
| Номхон зогсоод байвал | Гэрэл дохио хүлээлгүй |
| Дараагийн гэрэл солигдоно | Гэнэдэж битгий гүйгээрэй |

Д.Ганбүргэд

3 Илүүц үгийг олж, тайлбарлана уу.

улаан гэрэл	ногоон гэрэл
хөх гэрэл	шар гэрэл